

Х. Гаадан

**ДАНДИНЫ «ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛИЙН»
ХУРААХ БА ГҮТГЭХ ЧИМЭГ**

Энэ өгүүлэлд эртний Энэтхэгийн яруу найргийн онолч Дандины «Зохист аялгууны толь» гэдэг зохиолын II бүлэгт гардаг «Хураах үйлдэх чимэг», «Маш нэрийдэх буюу маш гүтгэх» чимэг хоёрын тухай өгүүлнэ. Эдгээр чимгүүдэд Дандины толийн төвд эхийг тавдугаар Далай лам Агваан Лувсанжамцын тайлбараар тайлбарлаж, өөрийн бодол дүгнэлтийг хавсарч өгүүлсэн болно. Лувсанжамцын тайлбарын онцлог нь а) хатуу нарийн нэр томъёо ба ухагдахууныг тайлбарласан, б) уг чимэг яруу сайхны ямар утга гаргаж байгааг дэлгэрүүлэн тайлбарлаж өгсөнд оршино. Иймд энэ өгүүлэл бол эртний Энэтхэгийн яруу найргийн онолыг судалж, орчин үеийн онол бодлоор дүгнэн, улмаар энэ зохиол монголын уран зохиол, яруу найрагт хэрхэн нөлөөлж байсныг шинжлэн үзэхэд тус нэмэр болгож байна.

1.Хураах чимэг. Энэ чимэгт хэрэглэгдэх нэр томъёог данжуурын орчуулганд хураан өгүүлэх гэсэн үгээр анх орчуулсан юм. Лувсанжамцын тайлбарт мөнхүү хураан өгүүлэх гэдэг нэр хэрэглэжээ. Энэ чимгийн гол утга бол өгүүлэхийг хүсч буй зүйлээ гаргахдаа түүнтэй адил чанарын үлгэр болох бусад зүйлийг өгүүлж, үлгэртнийхээ тухай хэлэлгүйгээр түүний сайхныг далдуур гаргах арга юм. Энэ бол мөн л адилтгалын нэг хэлбэр болно. Энэ чимэгт бэлэг чанарыг өгүүлэх, үлгэр гаргах гэж хоёр зүйл байна. Бэлэг чанарыг өгүүлэх тухай уг эхэд: «Зарим бодыг чухал зохиож, түүн лүгээ адил, бус бодыг хураахын ёсоор өгүүлэгч түүнийг хураан өгүүлэхүй дор таалмуй» гэж заажээ.

Тайлбар нь: «Өгүүлэхүйе хүссэн үлгэртэн болох аль нэг бодыг санаж, түүнтэй адил үлгэр болох бусад бодыг найруулан зохиохын үүднээс үлгэртнээ хураахын ёсоор өгүүлэн үйлдэх нь хураан өгүүлэгдэх ёс хэмээн тайлагдваа» гэжээ.

Хоёрдугаарт, үлгэр өгүүлэх ёс нь ерөнхий ба өвөрмөц гэсэн хоёр зүйлийг харуулна. а) Ерөнхий үлгэрийн талаар уг эхэд: «Зөгий ямар мэт хүсэгсээр хү, дэлгэр лянхуа дахь балыг уумуй, сайхан үнэр дэлгэрсэн бус боловч эсхүү нээгсэн цэцэгт найралдан ахуйг үзэгтүн» гэжээ.

Тайлбар нь: «Зөгийс хүссэн ёсоор лянхуагаас бал уугаад зогсохгүй, балын сайхан үнэр гаргаагүй, амаа нээгээгүй нялх цэцэгт ч гэсэн уруулаа учруулахыг үзэгтүн гэж буй нь үлгэр юмаа» гэжээ. Зөгий бал нь гүйцэж дэлбээ дэлгэсэн цэцгээс шимий нь уугаад зогсохгүй, түүнд амтшиж бас шим нь гүйцэж амаа нээгээгүй цэцэг рүү ч явдаг нь балын амт авсны шинж гэдгийг дурдаж энэ бүхэл үзэгдлээр үлгэр болгосон байна.

Энэхүү ерөнхий үлгэртэй холбогдсон жишээ шүлэг нь:

«Учир ёсыг сайтар эсэн мэдсэн тэнэгүүд
Улам улам бурууг шүтсээр холдон очиж

Галбарбаасан модны сэрүүн сүүдрийг орхин
Гандсан модны хуурай навчсын дор сууна за» гэжээ.

Энэ шүлэгт өгүүлж байгаа галбарвасан мод бол хүсэл бүхнийг хангадаг мод гэсэн домогтой юм. Нэгэнтээ хүсэл бүхнийг хангадаг юм болохлоор ертөнцийн бүх энэл зовлон, түүний дотор халууны энэлэлээс ч хамгаалж, сэрүүцүүлж өгөх ёстой гэдэг. Энэ домгоос үндэслэсэн ойлголтын дагуу тэнэг хүн сайхан юмыг орхиод муу юм руу явдаг шүү гэсэн утгыг дээрх шүлэгт өгүүлжээ.

б) Өвөрмөц үлгэрийг гаргахад товч үзүүлэх, үлгэр номлох гэж хоёр зүйл гарна. Товч үзүүлэх талаар уг эхэд заасан нь:

«Ялгамжитын төдий, тус бүр бөгөөд, ялангуяа зүйл адил ч буй амуй, Ялгал тус бүр бөгөөд тус бүр бус, энэ нь бус нугууд дор бээр буй» гэжээ.

Тайлбар нь: «Ялгаварт төдийгөөр тус тус бөгөөд ялгалт ном нь сайтар адил байх ба бас ялгалын уг нь тус тус байхад зарим ялгал нь тус тус, зарим нь тус тус бус байх юм. Эдгээрээс гадна бусад урьд байгаагүй зүйлийг энд хурааж өгүүлнэ» гэжээ.

Энэ тайлбарт гарч буй ялгаварт гэдэг үг бол ямар нэг юмны суурь буюу их бие гэсэн үг, ялгалт ном гэдэг нь ямар нэг юмны үе гишүү буюу салаа салбар гэсэн үг юм. Ингэхлээр энэ чимэг бол суурь нь адил байхад гишүү нь адил бус байх, эсвэл суурь нь адил байхад гишүү нь заримдаа адил, заримдаа адил биш байх үзэгдлийг харуулахаас гадна урьд огт гараагүй байсан үзэгдлийг гарсан гэж гүтгэж өгүүлэх аргаар адилтгалаа гаргах юм. Дэлгэр үзүүлэх талаар гурван үлгэр гаргаж заах болно. Үүнд:

1. Ялгалын уг тус тус (ондоо) байхад ялгалт гишүүн нь адил байхыг үзүүлж хураасан чимэг гэж байна.

Энэ бол их бие нь ондоо байтал эрхтэн гишүү нь адил болохыг хурааж өгүүлэх арга юм. Энэ тухай уг эхэд «Бас үндэст үрийн үүргээр хуяглагч нугууд насдаа дэлгэрэн үйлдээд, сүүдэр тусагч үүнийг би бээр үнэхээр олвоо» гэжээ.

Тайлбар нь: «Үлгэр болох их галбарвасан мод хийгээд үлгэрт болох их хүн (хаан) хоёр бие төрлөөр ондоо бөгөөтөл хийдэг ажил нь адил болохыг хэлж болно. Жишээ нь энэ хоёрын үндсийг бат бэх болгох гэж хэн ч оролцоогүй атал үнлэс нь бат байх, 4 эрдмээр болон оройныхоо тэмдгээр сүртэй байдгийн дээр гуйлагчин сэтгэлийг ямагт баясган үйлд-дэгээс гадна тус амгаланг өгөх хийгээд навчны сүүдэр нь сайхныг би бээр үнэхээр эдлэх болно гэж үлгэртнээ дотроо санаж үлгэрээ илт өгүүлэх болно» гэжээ.

Энэ чимэгт хаан, галбарбаасан мод хоёрыг адилтган өгүүлэхдээ бие төрөл нь ондоо боловч гүйцэтгэх үүрэг буюу эрдэм нь адил болохыг харуулжээ. Үндэс нь бат, орой нь сүртэй, хүнийг баясгадаг амгалан өгдөг, энэ чанар нь дээрх хоёрын аль алинд нь байдаг гэж харуулж байгаа юм. Жишээ шүлэг нь:

«Тэргэл сарны эхийн ёроол асар гүнзгий,
Тэр бээр эгээрлийг хангах чандманийг гаргамуй,
Алжаал уйтгаргүй огторгуйд зорчин наадан,
Адат үхээрээс холд орших сар гайхамшиг» гэжээ.

Энэ шүлэг нь сар далай хоёрыг адилтгаж өгүүлэхдээ сарны эх гэж далайг нэрлэдэг ёгт нэрээр нэрлэжээ. Эхний хоёр мөр шүлэг нь далайг хэлж, дараагийн хоёр мөр шүлэг нь сарыг хэлжээ. Чингэхдээ энэ хоёрын эрдэм болох сэтгэл баясгах чадлыг адилтган өгүүлсэн байна. Далай бол их бөгөөд чандмань эрдэнэ гаргадаг үйлстэй, сар бол огторгуйд зорчдог, муу юмнаас хол байдгаараа ариун сайхан байж сэтгэл баясгадаг

үйлстэй, энэ хоёрыг адилтгажээ. Далайг сарны эх гэж хуучин бичиг зохиолд өгүүлсэн зүйл олон бий. Энэ бол сар анх далайгаас гарсан гэдэг маш эртний домгоос үүссэн ойлголт юм.

2. Ялгалын уг нь адил байхад ялгалт гишүүн нь адил ба адил биш байдаг ёсыг хурааж өгүүлэх арга байна. Энэ бол үүний түрүүнд ярьсан их бие нь ондоо байхад үе гишүү нь адил байхыг харуулсан чимэг дээр үе гишүү нь бас адил биш байхыг нэмж үзүүлсэн хэрэг юм. Энэ тухай уг эхэд: «Гишүүний чинээн ину өчүүхэн бус бөгөөд цэцэг үрэн хотол төгсгөсөн, дээд бат сэрүүн сүүдэр лүгээ төгссөн, энэ модон миний заягаанд олдвоо» гэжээ.

Тайлбар нь: «Ялгалын уг нь тус тус байхад ялгалт гишүүн нь адил буюу адил биш хоёрыг хураан өгүүлэхэд бодыг өгүүлэх ба хоёулангийнх нь утгыг гаргах гэж хоёр зүйл байна.

Нэгдэх нь үлгэр, үлгэртэн хоёрын ялгалын уг суурь тус тус байх ёсыг саяхан бид номлосон билээ. Ялгалт гишүүн болох үе гишүүний эн нь их бөгөөд цэцэг үр хоёр нь нэгэн зэрэг дэлгэрч гайхамшигтай болох нь гагцхүү үлгэр болох галбарвасан модонд байдаг ялгалт юм. Тус амгалан өгөх ба навчийн сүүдрээрээ сэрүүцүүлдэг чанар болон батжуулах гэж оролдоогүй байтал бат болсон энэ нь дээд хүн, дээд модон хоёуланд нь байдаг ерөнхий зүйл юм. Энэ модон миний заяагаар надад олдвоо хэмээн өгүүлэх нь үлгэртнээ санаж байгаад үлгэрээ илт магтан өгүүлсэн хэрэг болно» гэжээ. Энэ тайлбар бол үлгэр ба үлгэртэн хоёрын аль алиных нь үе гишүүнд байдаг ялгалтай ба адил талуудыг тодруулан гаргав. Жишээ шүлэг нь:

«Асар сайхан сэтгэл булаам гоо биен дээр
Алимад товорцог мөчир сэлт найгана,
Эрхэм лянхуан үзэсгэлэнт энэ баглаа
Эргэх зөгийн нүдэнд зохис болдог ажээ» гэжээ.

Энэ шүлгийг ажиглаж үзвэл сэтгэл булаам гоо бие гэдэг нь цэцгийн эш бөгөөд ялгалын суурь болж өөрөө дээрээ үе гишүү болох товорцгийг найгуулсан нь ялгалын уг суурь, ялгалт гишүүн хоёр адил болохыг харуулжээ. Лянхуан үзэсгэлэнт баглаа зөгийн нүдэнд зохис болно гэвэл баглаан дээр харагдах түүнтэй адил үе гишүүн байхгүй, зөвхөн нүдийг баясгах эрдэм байж, зөгийн сэтгэлд зохис болсныг өгүүлсэн учир энэ нь суурьтайгаа адил бус үе гишүүн байгаагийн жишээ юм. Иймд энэ шүлэг гоо бие, лянхуан баглаа хоёр суурь дээр найгах товорцог, үзэх үзэсгэлэн гэж хоёр ондоо үе гишүүн оршиж нэг суурьтайгаа адил, нөгөө нь сууринаасаа ондоо (гаднах байдлаараа) болохыг харуулжээ.

Хоёулангийнх нь утгыг өгүүлэх талаар уг эхэд: «Хоёр бүрт ч зарим төрөлхтөн, мөнхүү галбарвасан модон чухал сайшааж, хамаг ном урьд нь ерөнхий бөгөөд нөгөө нь хоёр зүйл болой» гэжээ.

Тайлбар нь: «Сая номлосон хоёр зүйлд зарим нэг дээд хүмүүсийг санаж, илдээ галбарбаасан модыг сайшаан өгүүлж ялгалт гишүүнийх нь талаар урьдахь үлгэрт хоёуланд нь үе гишүүн байгааг харуулсан бол хойдохь үлгэрт нэгэнд нь байхаар нөгөөд нь байхгүйгээр (хэлбэрийн хувьд-Х.Г.) найруулсан болно» гэжээ.

Энэ эх ба тайлбар хоёр ерөнхийдөө нэг, хоёрдохь үлгэр хоёуланд нь холбогдолтой бөгөөд нэг үлгэрээр ерөнхий суурь дээр адил үе гишүүн байгааг харуулсан бус суурь дээр адил бус үе гишүүн байгааг харуулсан юм. Гэхдээ хоёр үлгэр хоёулаа илдээ үлгэрийг өгүүлж, далд ухаанаараа үлгэртнээ магтжээ.

3. Урьд гараагүйг хурааж өгүүлэх чимэг. Энэ бол үе тохиолдоогүй үзэгдлийг тохиолдсон мэтээр өгүүлж, үлгэртнээ магтах арга юм. Энэ чимэгт үлгэр гаргах, утга өгүүлэх гэж хоёр зүйл буй. Үлгэр гаргах ту-

хай уг эхэд: «Муу могойн нөхрөөс ангижирсан бөгөөд, өвөрчилэн иер амтутын дотор ая энэ усны сан ину, цаг иеэр угугаат ширгэх болоху» гэжээ.

Тайлбар нь «Анхдугаарт үлгэрт болох муу хааны явдал ёс лугаа эс нөхөрлөөд дээдсийн явдал ёсны өвөрмөц төрхөөр цэнгэгч буяны энэ сайн цагийн эрхээр үхэж болох гэж санаад жинхэнэ үлгэртнээ муу могойтой нөхөрлөхийг болиод, давсгүйн өвөр төрхтэй болсон далайтай аяа цагийн эрхээр хатах болвоо гэж хэлэх нь муу могой ба давсгүй далай байхгүй тул урьд гараагүйг өгүүлж байгаа хэрэг болно» гэжээ.

Энд гарч буй муу могой гэж лусын нэр юм. Ингэхлээр лус байдаггүй ба давс байхгүй тийм далай байхгүй гэдгийг өгүүлээд энэ нь хатах болно гэдэг нь бас л далай хатдаггүйг хэлж байгаа юм. Урьд гараагүйг өгүүлнэ гэдэг нь огт болохгүй зүйлийг өгүүлнэ гэсэн үг болно. Ингээд болохгүй, байхгүй юмыг болно, байна гэж илдээ өгүүлээд далд утгаараа муу ёсыг хаяж, сайн ёсыг олно гэсэн хүслээ илэрхийлж, энэ нь гагцхүү цагийн эрхээр болно гэнэ. Өөрөөр хэлбэл, цаг нь болоход болохгүй юм бүхэн болно гэж байгаа юм. Жишээ шүлэг нь:

«Гүн огторгуйд зугаацан эс аялдаг
Гүмэдийн цоморлогийг даран чадагч,
Саран чимэг нэгэнтээ байх болбаас
Садагнах миний зүрхэнд хэзээ ч гоо буюу» гэжээ.

Гүмэд гэж сар гармагц дэлбээгээ нээдэг цэцгийн нэр тул гүмэдийг даран чадагч гэж гүмдийг нээлгэдэггүй сар байвал гэсэн үг болно. Энэ нь миний зүрхэнд гоо буюу гэдэг нь үүргээ гүйцэтгэдэггүй сар надад сайхан санагдана гэж илдээ хэлээд, мөн чанартаа огторгуйд явдаггүй, гүмд цэцгийг нээлгэдэггүй сар гэж байхгүй, болохгүй юмыг өгүүлж байгад учраас урьд байхгүйг өгүүлсэн чимэг бүхий шүлэг мөн. Энэ чимгийн утга өгүүлэх хоёрдугаар зүйлийн, талаар уг эхэд: «Далайд түүн лүгээ адил төрөлхтний найдахуйг тодруулан үйлдээд урд номыг няцуулахын тулд, энэ нь урдгүйг хураах хэмээн өгүүлмүй» гэжээ.

Тайлбар нь: «Далайд байдаг тэр гэмийг үгүй гэж өгүүлснээр мөн тийнхүү санагдах адил зүйлийг хурааж байна. Үүгээрээ хүний эрдмийн дүрийг тодруулж, урьдах зүйлийг өөрчлөн хувиргаж, ертөнцөд алдаршсан ёсыг няцаасан тул энэ нь урьд гараагүйг хураан өгүүлсэн зүйл болно гэжээ.

Маш нэрийдэх буюу маш гүтгэх чимэг

Энэ чимэг Данжуурын монгол орчуулгад «сайтар ухагч» гэдэг нэртэй яваа юм. Уг төвд эхээрээ маш гүтгэх, маш нэрийдэх гэж хэлж болмоор үгээр бичигдсэн байна. Утга нь юмыг тийм болов уу, ийм болов уу, гэж зориуд мушгиж сэжиглэж нэрлэж өгүүлэх найруулгын арга юм. Үүгээр мөн хоёр юмыг адилтгаж, магтаж буй зүйлээ сайшаан товойлгох юм. Жишээ нь шөнийн сар огторгуйд мэлтэлзэн гарч ирэхэд хамаг амьтанд гэрэл болж өгөх гэсэн юм болов уу гэж өгүүлбэл сарны үйлсийг сэжиглэж өөрийн ойлголтоор түүний тухай тааварлан өгүүлэхийг ийнхүү нэрлэнэ. Энэ чимэгт а) бэлэг чанарыг өгүүлэх б) үлгэр гаргах, в) буруу онолыг хориглох, г) маш нэрийдэхийг тодорхойлох үгийг тайлбарлах гэж дөрвөн зүйл багтан орно. Бэлэг чанарыг өгүүлэх нэгдүгээр зүйлийн талаар уг эхэд: «Амьтан нугууд ба нөгөө бус зүйлд оршигсон ёсон, аливаа бус зүйлийг сайтар ухагч, түүнийг сайтар ухахуй хэмээн мэдэхүй бус, адилтгаваас» гэжээ.

Тайлбар нь: «Амь төгөлдөр амьтан буюу амьгүй бусад зүйлийн орших ёсыг тухайлж, ямар нэгэн бус бод орших ёсыг нэрлэн хэлж, өөр зүйлийг маш нэрийдэх буюу хүчлэн гүтгэж үзүүлсэн түүнийг маш нэрийдэгдэх

хэмээн ухаармуй» гэжээ. Энэ бол ямар нэг амьтныг тийм амьтан биш, тийм амьтан байх гэх буюу ямар нэг амьгүй зүйлийг мөн үүнчлэн өөрчлөн сэжиглэж нэрлэх, бас ямар нэг үйлсийн нь чанарыг өөрөөр тайлбарлах зэргээр цаад юмных нь чанарт тохируулахгүйгээр өөрчлөхийг хэлж байгаа юм.

Үлгэр гаргах хоёрдугаар зүйл гурав байна. Үүний анхдугаар: болох санаатай юм гэж гүтгэн гаргах чимэгт үлгэр утга хоёр байна.

1. Амьгүй амьтныг гүтгэн нэрлэх чимэг. Энэ бол ертөнцийн аль нэг үзэгдэл юм уу, хөдөлгөөнийг гүйцэтгэж буй амьтныг зориуд хийсэн ажил гэж гүтгэн өгүүлэх арга юм. Энэ тухай уг эхэд: «Загаан нугууд ану үдийн наран иеэр энэлэн нуурт ормуй, нарны нөхөр болгосон лянхуа нугуудыг дараахуяа таалах мөн бус хэмээн сэтгэмүй» гэжээ.

Тайлбар нь: «Эх заанууд нь өдрийн гол дунд нарны халуунаар энэлж, сэрүүцэхийн тулд лянхуан далайд ороход түүнийг нарны халуун энэлснийхээ хариуг авч нарны садан лянхуан чуулганыг дарах гэж байна хэмээн гүтгэн өгүүлжээ» гэсэн байна. Заан халууцаж, лянхуа ургасан усанд очиж орохыг зориуд гуйвуулж, заан лянхуа цэцгүүдийг тасдан үрэх гэж чингэж байгаа юм хэмээн мушгин өгүүлэв. Жишээ шүлэг нь:

«Сайхан хөхөмдөг үснийхээ үзүүрт
Саран чимэг зүүсэн эрхэмсэг янжин
Саар шөнийн гүн харанхуйг гийгүүлэхээр
Саруул гэрлээ тусгахыг таалсан биз» гэжээ.

Энэ шүлэг Янжинлхамын орой дээрх саран чимэгийн зорилгыг өгүүлэхдээ харанхуйг гийгүүлэх гэсэн байлгүй гэж нэрийдэж тааварлан өгүүлжээ. Уг нь янжинлхамын саран чимэг тус амгалангийн их үйлст хэрэгтэй ажээ. Энэ чимгийн утга өгүүлэх хоёрдугаар зүйлийн талаар уг эхэд «ухияхуй хийгээд уух ба лянхуан үндсэн нүгүүдийг идэхийн тулд заан уснаа орохуй түүнийг өшөө бээн авахын тулд хэмээн зохист аялгуучин бээр маш нэрийдэн өгүүлмүй» гэжээ.

Тайлбар нь: «Заан нь биеэ угааж, ус уух ба лянхуан үндэс идэхийн тулд усанд орохыг өш хонзон авахын тулд чингэж байна хэмээн зохист аялгуучин бээр маш гүтгэн өгүүлэв» гэжээ.

2. Амьгүй зүйлийг нэрийдэж өгүүлэх чимэг. Энэ бол ямар нэг амьгүй зүйлд хандаж чи тийм ийм болж байна уу гэж өгүүлэх арга болой. Энэ талаар үлгэр гаргах, утга өгүүлэх гэж хоёр зүйл байна. Үлгэр гаргах талаар уг эхэд: «Энэ хэмээвээс өврийн хол нугуудыг түргэтгэгч чихний чимэг хэмээх бөлгөө. Чиний нүдэн нь чиний удвал нугуудаас түрвэлэхүй мэт» гэжээ.

Тайлбар нь: «Гоо эхнэр үзэсгэлэн болгохын тулд удвал цэцгийг чихнийхээ дээд талд хатгасан нь нүдний зууван уртыг хорих гэж чихний чимэг болгон хэрэглэв хэмээсэн нь түүний хариуд чиний нүд зуйван урт харагдаж, чихний удвалаас түрүүлэх мэт болой» гэжээ. Энд чихний чимэг болгосон удвалыг гүтгэжээ. Удвал цэцгийг чинхэндээ хатгаж чимэг хийсэн нь нүднийхээ зуйван уртыг халхлах гэсэн байжээ гэж гүтгэн нэрийдээд далд ухаанаар нүдний зуйван урт жавхлан юунд ч дарагдахгүй. Чихэндээ зүүсэн удвал нүдний уртыг хориглож үл чадна, удвал энд чимэг болж чадахгүй нь ээ гэж байгаа юм.

Энэ чимгийг утга өгүүлэх хоёрдугаар зүйлийн талаар уг эхэд: нүдний Өнцгийн хур унаснаар нүдний гэрлийн удвалд хүрэх буюу бус боловч зохист аялгуучин тэр мэт сайтар нэрийдэж өгүүлмүй» гэжээ.

Тайлбар нь: «Нүдний өнцөг чихний удвалд хүрлээ» гэж нэрийдэн өгүүлж, нүдний урт нь удвал чимэгт хүрээгүй боловч зохист аялгуучнууд зориуд ингэж өгүүлж байгаа юм» гэжээ. Энэ нь нүд хичнээн ч зуйван урт байлаа гэсэн чихэндээ хүрэх гэж байхгүйг харуулж, нүдний уртыг дарах

гэсэн удвал тусгүй юм хийж байна даа гэж яруу найрагчид гүтгээд уг чанартаа нүдний сайхныг далдуур үзүүлж байгаа юм.

3. Ёроолыг нь барих нэрийтгэлийн чимэг. Аяндаа болсон үзэгдлийг зориуд зүйл шиг санаж өгүүлэхийг ийнхүү нэрлэнэ. Энэ талаар уг эхэд:

«Харанхуй нь бие дур шүрчигсэн мэт, огторгуй нь нүдний эмийн хур оруулсан мэт, хэмээгдсэн үүнийг маш нэрийдэхүй бэлэг чанар лугаа төгсөх маш олон болой» гэжээ.

Тайлбар нь: «Сэтгэл санаагүй шөнийн харанхуй бүрхэхийг санаатайгаар өөрийн биед эм түрхсэн шиг боллоо гэх, эсвэл сэтгэл санаагүй огторгуй зориуд сэтгэл санаатай юм шиг харанхуй болгов гэж давтах үг хэрэглэж нэрийдсэний бэлэг чанар лугаа төгөлдөр зүйл маш олон байна» гэжээ. Энд харанхуй болохыг зориуд хар юмаар бүрхэлээ гэх мэтээр гүтгэн нэрийдэж, зүйрлүүлэх санаагаа гаргах арга юм. Үүний жишээ шүлэг нь:

«Хээрийн сар алгуурхан гарч ирэхэд
Хээнцэр гүмд инээн баясах мэт
Зөгийн чуулганаас балаа харамласан цэцэг
Зөнгөөр байж үл чадан айж чичрэнэ» гэжээ.

Энэ нь ертөнцийн хууль зүйгээр өөрөө болж байгаа үзэгдлийг зориуд хийгдэж байгаа зүйл мэтээр нэрийдэн өгүүлж, далд утгаараа сэтгэл баясгаж чадах сайхан үзэгдлийг гаргажээ.

Буруу үзлийг хориглох, гуравдугаар зүйлийн талаар иш буюу зарчим лугаа харшлах, язгуур лугаа харшлах, сүүлий нь хураах гэж гурван зүйл байдаг байна. Энд хэлний дүрэм баримталж бичих ёсыг заажээ.

Эцэст нь нэрийтгэлд хэрэглэж болох хэсэг үгсийг жишээ болгож дурдсан байна.